



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
АСУУДАЛ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2012 оны 02 сарын 02 өдөр

Дугаар A/60

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. «Гадаадын иргэнийг түр саатуулах журам»-ыг нэгдүгээр, «Зөрчил гаргасан этгээдийг түр саатуулах тухай тэмдэглэл»-ийн загварыг хоёрдугаар, «Түр саатуулсан гадаадын иргэний бүртгэл»-ийн загварыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын хэлтсийн дарга (Л.Батсүх), тус Газрын хилийн боомт, орон нутаг дахь Албаны дарга, ахлах мэргэжилтэн нарт тус тус үүрэг болгосугай.

3. «Түр саатуулсан гадаадын иргэний бүртгэл»-ийг дэвтэр болгон хэвлүүлэх зардлыг Газрын холбогдох төсвөөс гаргахыг Санхүү, аж ахуйн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Л.Бямбадорж)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.МӨРӨН

Гадаадын иргэн, харьяатын асуудал
эрхлэх газрын даргын 2012 оны 4/60 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

Гадаадын иргэнийг түр саатуулах журам

1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар гадаадын иргэнийг паспорт буюу түүнийг орлох баримт бичиггүй, эсхүл хэн болох нь тогтоогдохгүй байгаа, түүнчлэн зөрчил гаргасан этгээдийг шүүхийн шийдвэрээр саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох зорилгоор гадаадын иргэнийг захиргааны журмаар түр саатуулах, бүртгэх, гаргасан шийдвэрийг цуцлах, захиргааны хариуцлагаас чөлөөлөх үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Гадаадын иргэнийг захиргааны журмаар түр саатуулах ажиллагааг Монгол Улсын Үндсэн хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хууль болон энэ журмын дагуу гүйцэтгэнэ.

1.3. Энэхүү журам нь харьяалалгүй хүнд нэгэн адил хамаарна.

Хоёр. Гадаадын иргэнийг захиргааны журмаар түр саатуулах ажиллагаа

1.1. Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч /цаашид «хяналтын улсын байцаагч» гэх/ нь паспорт буюу түүнийг орлох баримт бичиггүй эсхүл хэн болох нь тогтоогдохгүй байгаа, шүүхийн шийдвэрээр саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох зорилгоор гадаадын иргэнийг саатуулах байр болон эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тогтоосон газарт захиргааны журмаар түр саатуулж болно.

2.2. Гадаадын иргэнийг захиргааны журмаар түр саатуулахад зөрчлийн шинж, хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

2.3. Гадаадын иргэнийг захиргааны журмаар түр саатуулах хугацаа 6 цагаас илүүгүй байна.

Гурав. Гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн эрх, үүрэг

3.1. Хяналтын улсын байцаагч нь зөрчилд холбогдсон гадаадын иргэнд тухайн зөрчлийн талаар тайлбар өгөх, хүсэлт гаргах, хууль зүйн туслалцаа авах талаар эрх, үүргийг нь танилцуулна.

3.2. Хяналтын улсын байцаагч нь паспорт буюу түүнийг орлох баримт бичиггүй, эсхүл хэн болох нь тогтоогдохгүй байгаа гадаадын иргэнийг маягт /энэ журмын 2 дугаар хавсралт/-ын дагуу зөрчлийн тэмдэглэл үйлдэн гарын үсэг зурж, түр саатуулагдах гэж байгаа гадаадын иргэнд танилцуулж гарын үсэг зуруулна.

3.3. Зөрчилд холбогдсон гадаадын иргэнийг түр саатуулах үндэслэлтэй танилцан Хяналтын хэлтсийн дарга, хилийн боомт, орон нутаг дахь Албадын дарга болон тэдгээрийг орлон хиллаж буй албан тушаалтан зөвшөөрөл олгож тэмдэглэлд гарын үсэг зурж баталгаажуулна.

3.3. Захиргааны журмаар түр саатуулагдсан этгээд гарын үсэг зурахаас татгалзсан тохиолдолд тайлбар бичиж тэмдэглэлд хавсаргана.

3.4. Хяналтын улсын байцаагч нь саатуулагдсан гадаадын иргэний талаар нэгдсэн бүртгэлд тухай бүр тэмдэглэж, гарын үсэг зурж баталгаажуулна.

3.5. Түр саатуулагдсан гадаадын иргэний талаар түүний гэр бүл, уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн өмгөөлөгчид мэдэгдэх үүрэгтэй.

3.6. Гадаадын иргэнийг түр саатуулсан үндэслэл арилмагц хяналтын улсын байцаагч нь түүнийг нэн даруй чөлөөлж, энэ талаар нэгдсэн бүртгэлд тэмдэглэнэ.

Дөрөв.Түр саатуулагдсан гадаадын иргэний эрх , үүрэг

4.1. Зөрчил гаргасан гадаадын иргэн нь ямар зөрчилд холбогдсон, ямар эрх, үүрэгтэйгээ мэдэх, түүнтэй танилцах эрхтэй.

4.2. Захиргааны журмаар түр саатуулагдсан гадаадын иргэн нь хаана, ямар газар, албан тушаалтны мэдэлд байгаагаа мэдэх, өөрийн гэр бүл, уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон өмгөөлөгчдөө мэдэгдэх эрхтэй.

4.3. Захиргааны журмаар түр саатуулагдсан гадаадын иргэн нь хяналтын улсын байцаагчийн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо дээд шатны хяналтын улсын байцаагчид гаргах эрхтэй.

4.4. Хяналтын улсын байцаагчийн болон харуул хамгаалалтын ажилтны тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.


Тав. Түр саатуулж болохгүй гадаадын иргэн

5.1. Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу дипломат эрх ямба, дархан эрхтэй.

5.2. Илтэд мэдэгдэх өвчтэй, жирэмсэн болон насанд хүрээгүй гадаадын иргэн.

-----oOo-----

Гадаадын иргэн, харьяатын асуудал
эрхлэх газрын даргын 2012 оны 1/60 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



ЗӨВШӨӨРСӨН:

**ЗӨРЧИЛД ХОЛБОГДСОН ГАДААДЫН ИРГЭНИЙГ
ТҮР СААТУУЛАХ ТУХАЙ ТЭМДЭГЛЭЛ**

20.... оны.....сарын.....өдөр

(үйлдсэн газар)

Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч..... овогтойби

Монгол Улсын Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3-т заасныг үндэслэн 20....оны.....сарын..... өдөр.....цаг.....минутанд дор дурдсан этгээдийг түр саатуулахаар тогтов.

Түр саатуулагдсан гадаадын иргэний мэдүүлснээр:

1. Улсын нэр.....
2. Овог нэр.....
3. Төрсөн огноо, хүйс.....
4. Оршин суугаа хаяг.....
5. Өөрт нь байгаа баримт бичгийн дугаар.....
6. Зөрчлийн талаарх тэмдэглэл:

Уригч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гэр бүл, өмгөөлөгчид мэдэгдсэн талаар:

Утасны №..... 20.... онысарынөдрийн.....цаг.....минутанд мэдэгдэв.

Тэмдэглэл үйлдсэн: хяналтын улсын байцаагч/...../

(гарын үсэг) (нэр)

Тэмдэглэлтэй танилцсан гадаадын иргэн:/...../

(гарын үсэг) (нэр)

Хүлээн авсан:/...../...../...../

(газар) (албан тушаал) (гарын үсэг) (нэр)

.....он.....сар.....өдөр.....цагминут.

Чөлөөлсөн тухай тэмдэглэл: 20.... оны.....сарын.....өдөр.....цаг.....минут

Чөлөөлсөн: хяналтын улсын байцаагч:/...../

(гарын үсэг) (нэр)

Гадаадын иргэн, харьяатын асуул
эрхлэх газрын даргын 2012 оны 10 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

ТҮР СААТУУЛСАН ГАДААДЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛ

№	Харьяалах улсын нэр	Овог нэр, Төрсөн огноо	Хүйс	Саатуулагдсан газар, үндэслэл	Саатуулсан хяналтын улсын байцаагч	Саатуулсан огноо, цаг, минут	Тайлбар	Чөлөөлсөн огноо, цаг минут